

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.9. Аудитын илрүүлэлт .....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ  
ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ I  
ШАТНЫ ТӨСЛИЙН ЗАХИРАЛ  
Ч.БАТСАНСАР ТАНАА

2021.08.25 № 07/488  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал, дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн, үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 84.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу, үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Аудит хийсэн санхүүгийн тайлан

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,653,651,170.39</b>	<b>1,303,669,147.30</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,644,738,451.33</b>	<b>1,290,721,313.10</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,644,738,451.33	1,290,721,313.10
31211	Төрийн банкны харилцах төгрөг	51,520,000.00	626,671.38
31221	Төрийн банкны харилцах /евро/	1,593,218,451.33	1,290,094,641.72
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>0.00</b>	<b>8,008,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	8,008,000.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>8,912,719.06</b>	<b>4,939,834.20</b>
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>8,912,719.06</b>	<b>4,939,834.20</b>
35410	Бичиг хэргийн материал	5,563,075.00	3,400,570.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,724,091.00	844,091.00
35460	Бусад Хангамжийн материал	1,625,553.06	695,173.20
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>132,137,999.89</b>	<b>87,829,589.71</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>132,137,999.89</b>	<b>87,829,589.71</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,475,000.00	98,475,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(39,937,080.90)	(59,960,329.68)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	71,766,090.00	71,766,090.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,041,970.93)	(41,634,423.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,613,940.87	42,613,940.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,742,898.25)	(25,407,757.93)
39301	Програм хангамж	3,004,919.10	1,977,070.32
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,785,789,170.28</b>	<b>1,391,498,737.01</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>25,926,534.27</b>	<b>0.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>25,926,534.27</b>	<b>0.00</b>
41300	<b>Өглөг</b>	<b>25,926,534.27</b>	<b>0.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	25,926,534.27	0.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,759,862,636.01</b>	<b>1,391,498,737.01</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,759,862,636.01</b>	<b>1,391,498,737.01</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	1,759,862,636.01	1,391,498,737.01
51210	Өмнөх үеийн үр дүн	672,018,328.75	1,759,862,636.01
51220	Тайлант үеийн үр дүн	1,087,844,307.26	(368,363,899.00)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,785,789,170.28</b>	<b>1,391,498,737.01</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>6,641,171,251.93</b>	<b>4,555,887,695.05</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,169,671,251.93</b>	<b>4,555,887,695.05</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>398,095,000.38</b>	<b>390,478,923.60</b>
120002	Хүүгийн орлого	28,367,032.65	14,861,676.88
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	364,940,187.73	375,617,246.72
120009	Бусад орлого	4,787,780.00	0.00
122	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>5,771,576,251.55</b>	<b>4,165,408,771.45</b>
122002	Хандив-Гадаад	5,771,576,251.55	4,165,408,771.45
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>471,500,000.00</b>	<b>0.00</b>
131	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>471,500,000.00</b>	<b>0.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	471,500,000.00	0.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,598,293,581.97</b>	<b>1,908,344,016.58</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,250,983,079.18</b>	<b>1,908,344,016.58</b>
210	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,798,040,221.40</b>	<b>1,532,726,769.86</b>
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,741,138.40</b>	<b>0.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,903,974.20	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,459,291.00	0.00
210203	ҮОМШ өвчний даатгал	1,967,432.90	0.00
210204	Ажилгүйдлын даатгал	491,858.20	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,918,582.10	0.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>66,002,985.33</b>	<b>0.00</b>
210301	Гэрэл цахилгаан	1,103,849.00	0.00
210302	Түлш, халаалт	191,776.37	0.00
210304	Байрны түрээс	64,707,359.96	0.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,428,854.66</b>	<b>9,081,854.93</b>
210401	Бичиг хэрэг	6,394,071.00	2,162,505.00
210402	Тээвэр шатахуун	4,587,850.00	5,395,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,029,693.76	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	417,239.90	644,349.93
210408	Бараа материал акталсны зардал	0.00	880,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>286,029.93</b>
210503	Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	0.00	286,029.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	<b>2,837,636.36</b>
210604	Урсгал засвар	0.00	2,837,636.36
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,544,275.82</b>	<b>0.00</b>
210701	Гадаад албан томилолт	7,339,180.82	0.00
210702	Дотоод албан томилолт	7,205,095.00	0.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,621,175,616.51</b>	<b>1,476,212,838.46</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,615,653,061.24	1,474,726,670.77

210803	Даатгалын үйлчилгээ	2,488,304.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,548.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,836,703.27	1,486,167.69
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50,147,350.68</b>	<b>44,308,410.18</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,640,821.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	43,506,529.68	44,308,410.18
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>452,942,857.78</b>	<b>375,617,246.72</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	364,940,187.73	375,617,246.72
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	364,940,187.73	375,617,246.72
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>88,002,670.05</b>	<b>0.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,002,670.05	0.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,347,310,502.79</b>	<b>0.00</b>
220001	Барилга байгууламж	2,103,277,957.23	0.00
222001	Тоног төхөөрөмж	1,244,032,545.56	0.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>1,042,877,669.96</b>	<b>2,647,543,678.47</b>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>178,071,395.44</b>	<b>364,869,286.81</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	178,071,395.44	364,896,286.81
5	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>133,104,758.14</b>	<b>3,380,803,864.28</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	133,104,758.14	115,002,309.09
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	0.00	3,265,801,555.19
6	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>1,087,844,307.26</b>	<b>(368,363,899.00)</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,568,378,532.65</b>	<b>1,124,452,676.88</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,096,878,532.65</b>	<b>1,124,452,676.88</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>28,367,032.65</b>	<b>14,861,676.88</b>
120002	Хүүгийн орлого	28,367,032.65	14,861,676.88
122	<b>Тусламжийн орлого</b>	<b>5,068,511,500.00</b>	<b>1,109,591,000.00</b>
122002	Хандив тусламж-гадаад	5,068,511,500.00	1,109,591,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>471,500,000.00</b>	<b>0.00</b>
130	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>471,500,000.00</b>	<b>0.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	471,500,000.00	0.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,135,264,181.87</b>	<b>1,153,721,723.11</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,135,264,181.87</b>	<b>1,153,721,723.11</b>
210	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,047,244,916.32</b>	<b>1,153,721,723.11</b>
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,741,138.40</b>	<b>0.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,903,974.20	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,459,291.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,967,432.90	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	491,858.20	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,918,582.10	0.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>66,002,985.33</b>	<b>0.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,103,849.00	0.00
210302	Түлш, халаалт	191,776.37	0.00
210304	Байрны түрээс	64,707,359.96	0.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,450,283.76</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	5,335,490.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	4,999,300.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,029,693.76	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	85,800.00	0.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,389,680.82</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	13,389,680.82	0.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>915,276,862.01</b>	<b>1,153,721,723.11</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	915,276,862.01	1,153,721,723.11
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,383,966.00</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,383,966.00	0.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>88,019,265.55</b>	<b>0.00</b>
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>88,019,265.55</b>	<b>0.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,019,265.55	0.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>4,433,114,350.78</b>	<b>(29,269,046.23)</b>

5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,349,829,502.79</b>	<b>570,808,473.32</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,349,829,502.79</b>	<b>570,808,473.32</b>
220001	Барилга байгууламж	2,103,277,957.23	323,232,380.45
222001	Тоног төхөөрөмж	1,244,032,545.56	247,576,092.87
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардал	2,519,000.00	0.00
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>44,983,232.80</b>	<b>246,060,381.32</b>
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	178,071,395.44	374,002,813.30
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	178,071,395.44	374,002,813.30
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	133,088,162.64	127,942,431.98
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	133,088,162.64	127,942,431.98
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>1,128,268,080.79</b>	<b>(354,017,138.23)</b>
87	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>516,470,370.54</b>	<b>1,644,738,451.33</b>
88	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,644,738,451.33</b>	<b>1,290,721,313.10</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>695,108,159.75</b>	<b>695,108,159.75</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(23,089,831.00)	(23,089,831.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	672,018,328.75	672,018,328.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>1,087,844,307.26</b>	<b>1,087,844,307.26</b>
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>1,759,862,636.01</b>	<b>1,759,862,636.01</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,759,862,636.01	1,759,862,636.01
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>(368,363,899.00)</b>	<b>(368,363,899.00)</b>
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>1,391,498,737.01</b>	<b>1,391,498,737.01</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,550,000,000.00</b>	<b>4,784,181,564.28</b>	<b>1,765,818,435.72</b>	<b>73.04</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,700,000,000.00</b>	<b>1,510,372,009.09</b>	<b>189,627,990.91</b>	<b>88.85</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,700,000,000.00</b>	<b>1,510,372,009.09</b>	<b>189,627,990.91</b>	<b>88.85</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,700,000,000.00</b>	<b>1,510,372,009.09</b>	<b>189,627,990.91</b>	<b>88.85</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,700,000,000.00	1,510,372,009.09	189,627,990.91	88.85
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,850,000,000.00</b>	<b>3,273,809,555.19</b>	<b>1,576,190,444.81</b>	<b>67.50</b>
Барилга байгууламж	550,000,000.00	323,232,380.45	226,767,619.55	58.77
Тоног төхөөрөмж	4,300,000,000.00	2,950,577,174.74	1,349,422,825.26	68.62
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>6,550,000,000.00</b>	<b>1,644,738,451.33</b>	<b>4,905,261,548.67</b>	<b>25.11</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,550,000,000.00</b>	<b>4,180,270,448.33</b>	<b>2,369,729,551.67</b>	<b>63.82</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>14,861,676.88</b>	<b>-14,861,676.88</b>	<b>0.00</b>
Хүүгийн орлого	0.00	14,861,676.88	-14,861,676.88	0.00
<b>Тусламжийн орлого</b>	<b>6,550,000,000.00</b>	<b>4,165,408,771.45</b>	<b>2,384,591,228.55</b>	<b>63.59</b>
Хандив тусламж /гадаад/	6,550,000,000.00	4,165,408,771.45	2,384,591,228.55	63.59
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>0.00</b>	<b>1,644,738,451.33</b>	<b>(1,644,738,451.33)</b>	<b>0.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>0.00</b>	<b>1,290,721,313.10</b>	<b>(1,290,721,313.10)</b>	<b>0.00</b>
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>14</b>	<b>12</b>	<b>2</b>	<b>85.7</b>
Удирдах ажилтан	1	1	0	100
Гүйцэтгэх ажилтан	13	11	1	84.6
Үйлчлэх ажилтан	0	0	0	0.0
Гэрээт ажилтан	0	0	0	0.0

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн захирал Ч.Батсансар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээллэх, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарч ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 21-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар Интер аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, ахлах аудитор С.Уртнасан, аудитор Б.Гомбо нар хариуцаж хэрэгжүүлэв.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 155/2021 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төсөл нь 2020 оны үйл ажиллагааг үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлж, үр ашигтайгаар төлөвлөх, төслийн хүрээнд хийгдэх худалдан авах ажиллагаанд ил тод өрсөлдөх тэгш эрхийн боломжийг хангах, төлөвлөгөөний хэрэгжилт, төслийн тогтвортой байдлыг ханган ажиллах зорилт дэвшүүлэн ажилласан байна

Төслийн хүрээнд 2020 онд нийт төлөвлөсөн ажлаас орчны бүсийн зөвлөхийн ажил, тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого төлөвлөлт, стандарт, аргазүйг сайжруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, хамгаалалтын захиргааны бүтэц үйл ажиллагаа, байгаль хамгаалагчдад шаардлагатай техник хэрэгслийн үнэлгээ хийх зэрэг ажлууд ирэх оны төлөвлөгөөнд орж хойшилсон байна.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 84.2 хувь байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Германы Сэргээн Босголтын Зээлийн Банк (KfW)-ны худалдан авах ажиллагааны тухай “Түншлэгч Улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны удирдамж” 2019 онд шинэчлэгдэн 2020 оноос хэрэгжиж эхэлсэн.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, зөвлөмж өгсөн.

2020 оны шилэн дансанд шалгалт хийгээгүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,908,344.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 38,166.9 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 394,290.4 мянган төгрөгөөр буюу 22.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,644,738.4	1,290,721.3	(354,017.1)
Урьдчилгаа	0.0	8,008.0	8,008.0
Бараа материал	8,912.7	4,939.8	(3,972.9)
Үндсэн хөрөнгө	132,138.0	87,829.5	(44,308.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,785,789.2</b>	<b>1,391,498.7</b>	<b>(394,290.5)</b>
Өр төлбөр	25,926.5	0.0	(25,926.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,759,862.6	1,391,498.7	(368,363.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,785,789.2</b>	<b>1,391,498.7</b>	<b>(394,290.5)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,290,721.3 мянган төгрөг болж 354,017.1 мянган төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Засгийн Газраас санхүүжилт олгоогүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,939.8 мянган төгрөг болж 3,972.9 мянган төгрөгөөр буурсан нь II, III шатны төслийн үйл ажиллагаа эхэлж, зөвхөн I шатны төслийн бараа материалыг худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 87,829.5 мянган төгрөг болж 44,308.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдэл тооцож бүртгэсэнтэй нь холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,391,498.7 мянган төгрөг болж 368,363.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,085,283.5 мянган төгрөгөөр буюу 31.4 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 3,689,949.6 мянган төгрөгөөр буюу 65.9 хувиар буурсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,550,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 6,550,000.0 мянган төгрөгийн төсвийг гадаадын хандив тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,784,181.6 мянган төгрөг буюу 73.0 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 189,628.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,576,190.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь орчны бүсийн зөвлөхийн ажил, тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого төлөвлөлт, стандарт, аргазүйг сайжруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, хамгаалалтын захиргааны бүтэц үйл ажиллагаа, байгаль хамгаалагчдад шаардлагатай техник хэрэгслийн үнэлгээ хийх зэрэг ажлууд хийгдээгүйтэй холбоотой байна.

2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газраас төлөгдсөн санхүүжилтийн задаргааг дараах хүснэгтээр харуулав.

/Мянган төгрөгөөр/

№	Эдийн засгийн ангилал	Эдийн засгийн ангиллын нэр	Хаанаас	Дүн	Нэмэлт мэдээлэл
1	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	Тусгай дансаар	1,153,721.7	Тендерээр зохион байгуулагдсан зөвлөх үйлчилгээ, төслөөс зохион байгуулсан сургалт, ажлын хэсгийн хурал, татварын төлбөрт
			Германаас шууд төлбөрөөр	356,650.2	Төслийн олон улсын зөвлөх багийн төлбөрт
2	220001	Барилга байгууламж	Тусгай дансаар	323,232.3	Хустай нурууны Байгалийн цогцолбор газрын байгаль хамгаалагч, судлаачдын байр болон Төслийн хүрээнд баригдсан барилгуудад ариун цэврийн байгууламж, эко жорлон барих барилгын ажлын төлбөрт /Архангай, Төв, Хэнтий, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг/
3	222001	Тоног төхөөрөмж	Тусгай дансаар	247,576.1	Төслийн хүрээнд баригдсан Хамгаалалтын захиргаад, СМТ, Байгаль хамгаалагчийн байруудад тавилга нийлүүлэх, сейфний төлбөрт
			Германаас шууд төлбөрөөр	2,703,001.1	Дэд төслийн орчны бүсэд 16 суманд эмнэлгийн түргэн тусламжийн хэрэгслээр тоноглогдсон автомашин нийлүүлэх мөн дэд төсөлд хамрагдсан 9 хамгаалалтын захиргаадад UTV завь, цасны мотоцикл, хогны машин нийлүүлэх төлбөрт



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 220,210.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	220,210.0	4	220,210.0	0	0	100

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төсөл худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, төсөл нь 2021 оны 12 дугаар сарын 31-нээр хаагдах тул төслийн хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөний талаар нийт 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Тайлант үед 8,008.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авахаар төлбөрөө төлсөн боловч Ковид-19 цар тахлын улмаас тайлант үеийн эцэст хүлээн авч амжаагүй буюу гааль дээр хүлээгдэж байна. УСНББОУС-ын дагуу үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шалгуур нь хангагдаагүй байхад санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэснийг “урьдчилж төлсөн зардал”-аар бүртгэж залруулулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар төлбөрийн акт болон албан шаардлага өгөөгүй.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар нийт 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн Банк хооронд байгуулсан 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр төслийн I үе шатыг Монгол Улсын Засгийн Газрын талаас нэмэлт санхүүжилтгүйгээр 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаад байна.

Иймд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төсөлд бүртгэлтэй хөрөнгүүдийн ашиглалт, хөдөлгөөнийг анхаарч авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д Дараах этгээд захиалагч байна, 4.1.3-д Өрийн удирдлагын тухай хуулийн 4.121-д заасан төсөл хэрэгжүүлэгч гэж заасны дагуу тус төслийн нэгж нь уг хуулийн 21 дүгээр зүйл Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх, 21.1-д Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 1.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим алдагдах.

#### 1.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллах.

#### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

### 2. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

#### 2.1. Илрүүлэлт:

Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн Банк хооронд байгуулсан 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр төслийн I үе шатыг Монгол Улсын Засгийн Газрын талаас нэмэлт санхүүжилтгүйгээр 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаад байна. Иймд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төсөлд хаагдахаас өмнө балансад бүртгэлтэй хөрөнгүүдийг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

#### 2.2. Эрсдэл:

Балансад бүртгэлтэй хөрөнгүүд хариуцах эзэнгүй болох.

#### 2.3. Өгсөн зөвлөмж:

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төсөлд бүртгэлтэй хөрөнгүүдийг холбогдох этгээдэд шилжүүлэх талаар Төслийн удирдах хороо болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны өмч хамгаалах Байнгын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлэх.

#### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02.23</b>	Аудитын нэр: <b>2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2021/18/СТА-ТХН</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төсөл</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д Дараах этгээд захиалагч байна, 4.1.3-д Өрийн удирдлагын тухай хуулийн 4.121-д заасан төсөл хэрэгжүүлэгч гэж заасны дагуу тус төслийн нэгж нь уг хуулийн 21 дүгээр зүйл Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх, 21.1-д Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Худалдан авах ажиллагааны ажилтан	Ц.Амарбаяр, Ц.Оюунбилэг
2	Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн Банк хооронд байгуулсан 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр төслийн I үе шатыг Монгол Улсын Засгийн Газрын талаас нэмэлт санхүүжилтгүйгээр 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаад байна. Иймд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төсөлд хаагдахаас өмнө балансад бүртгэлтэй хөрөнгүүдийг холбогдох этгээдэд шилжүүлэх талаар төслийн удирдах хороо болон байгаль орчин, аялал жуулчлалын яамны өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.	-	Зөвлөмж өгөх	Санхүүгийн ажилтан	И.Хишигжаргал



